

THE ORAL HISTORY OF TWENTIETH CENTURY MONGOLIA



Sugir

Basic information

Interviewee ID: 990046
Name: Sugir
Parent's name: Hühhendүү
Ovog: Ih Ōlziit
Sex: m
Year of Birth: 1963
Ethnicity: Halh

Additional Information

Education: higher
Notes on education:
Work: sumyn zasag darga
Belief: Buddhist
Born in: Manlai sum, Ōmnōgovi aimag
Lives in: Manlai sum (or part of UB), Ōmnōgovi aimag
Mother's profession: herder
Father's profession: herder

Themes for this interview are:

(Please click on a theme to see more interviews on that topic)

education / cultural production; childhood; work; family; privatization; military;

Alternative keywords suggested by readers for this interview are: (Please click on a keyword to see more interviews, if any, on that topic)

democracy; contemporary Mongolia; military service; 7th meeting of the federation of cooperatives; education; boarding school; socialist awards; climate change; place names; childhood; education; army; brigade; socialism; democracy; morality; press; cultural centre; hunting; climate change;

Click here to submit your own keywords for this interview

Please click to **read an English summary** of this interview

Transcription:

Оюунтунгалаг -

Би Манлай сумын Засаг дарга Хүүхэндүүгийн Сугиртай уулзаж байна, ингээд танд би сая судалгааныхаа учрыг хэлээд бас нэг 2 зүйлийн зөвшөөрөл авсан тийм ээ, тэгээд та ингээд хэрвээ тэрийг зөвшөөрч байвал өөрийнхөө амьдралын түүхийг яриад эхлэхгүй юу?

Сугир -

За миний хэлсэн зүйлийг бол нийтэлж болно, нууцлаад байх юм байхгүй ээ, одоо ингээд шууд яриад явчих уу?

Оюунтунгалаг -

Тэгье.

Сугир -

За би 1963 оны 6-р сарын 22-нд Хүүхэндүүгийн 6-р хүү болон төрсөн. Би эхээс 11-лээ өссөн, би одоо 11 хүүхдийн яг дундах нь, одоо надаас дээш 5, доош 5 дүү байна, 5 эгч, ах, 5 дүү байна. За 1963 онд төрөөд, 1972 онд 9 настайдаа энэ Манлай сумынхаа бага сургуульд орж суралцсан, тэгээд яагаад 9 настайдаа сургуульд суралцсан бэ гэхээр зэрэг тэр үед бол хүүхэд 8 настай суралцдаг байсан л даа. Тэгээд манай аав, ээж бол хөдөө нэгдлийн тэмээ малладаг байлаа, нэгдлийн 300-аас 400 тэмээг малладаг. Манайх чинь одоо нэг үе 0-оос 10 насны 7 хүүхэд байлаа л даа. Тэгээд манай аав, ээж хоёр 300-аас 400-д тэмээтэй тэгээд 0-оос 10 насны 7 хүүхэд өсгөдөг одоо ийм байлаа. Тэгээд энэ бол одоогийн энэ яг энэ байдлаас харахад бол үгүй ер нь одоо энэ хүмүүс яаж энэ их ажлыг амжуулж байсан юм бол гэмээр үе бол зөндөө л одоо харагддаг л даа, тэр 7 хүүхдийг чинь, 0-оос 10 насны 7 хүүхдийг өсгөхдөө тэр хүүхдүүдийн бүх хувцсыг манай ээж ганцаараа оёно. Тэр үед чинь үйлдвэрээс авдаг хувцас гэж бараг байгаагүй шүү дээ. Хүүхдүүдийн дотуур хувцас, тэгээд гадуур тэрлэг тэгээд өмд, цамц одоо тэгээд бид нар бол ер нь одоо бага сургууль төгсгөлөө дандаа ээжийнхээ л оёсон бүх хувцасыг л, гутлаас бусад бүх хувцсыг л ээжийнхээ оёсон хувцсыг л өмсөж л хүн болсон л доо. Тэгээд зөвхөн бид хүүхдүүдийг өсгөөд, хүүхдүүдийг хувцаслаад зогсохгүй тэгээд манай ээж чинь одоо тэр 10 хэдэн ам бүлийн бүгдийнх нь хоол ундыг хийдэг, дээр нь одоо бүх ингэ малаа саадаг, мал хуйгаа усалдаг. За манай аав бол малаа тэмээгээ одоо хариулах, услах одоо хүнд хүчир ажлыг нь хийдэг ийм л байлаа. Тэгэхээр 8 настай хүүхэд гэдэг бол манай аав, ээжид бол одоо ер нь их тусд орсон, их одоо тийм тэмээ унаад.

Оюунтунгалаг -

Гарын үзүүрт хамаг л ажлыг хийлгэхэд болох?

Сугир -

Тийм, гарын үзүүрт зарагддаг, тэмээ унаад бас ойр зуур усны хооронд явчихдаг ийм л байсан учраас л манайх чинь одоо бүх л хүүхдүүдээ дандаа 8 настай суулгалгүй нэг жил өнжөөгөөд ингээд 9 настай сургуульд суулгаж байсан юм. За тэгээд нэг жил өнжөөгийн тулд тэр үед чинь нөгөө сургуульд хамруулах, хамруулах гэж төр, захиргааны байгууллагаас маш их шахдаг, тэгээд нэг жил хүүхдээ завсарлуулсан айлыг бол 200 төгрөгөөр торгодог байсан, тэр үеийн 200 төгрөг ч одоо нилээн том л мөнгө байсан байх.

Оюунтунгалаг -

За.

Сугир -

Манайх бол жил болгон л 200 төгрөгөөр торгуулаад л ингээд хүүхдээ заавал 9 настай сургуульд суулгадаг ийм байлаа. Тэгээд яахав 9 настай сургуульд суусны юугаар би чинь 9 дүгээр ангиа төгсөөд тэгээд энэ Цэций суманд 9-р ангиа төгсөөд тэндээсээ цэрэгт татагдсан.

Оюунтунгалаг -

9-р ангиа төгсөөд?

Сугир -

9-р ангиа төгсөөд, тэгээд яахав ийм сонин түүх байдаг л даа. 9-р анги төгсөөд нэгэнт 18 хүрсэн, манай ангиас 3 хүүхэд 18 нас хүрсэн юм. Тэгээд гурвуулаа Цэций сумын залуучуудтай хамт аймгийн төвд очиж цэргийн комисст орсон юм. Сургуулийн захирал энэ тэр ч бүгд л Цэцийнх учраас тэр цэргийн комисст очихгүй, бидэнтэй хамт манай сургуулийн 3 багш цэрэгт татагдсан.

Оюунтунгалаг -

/инээв/.

[Mongolian version](#)

[Back home](#)

[Website Tips](#)

[Interviews](#)

[Gallery](#)

[Mongolia](#)

[Project](#)

[Project Team](#)

[Oral History Resources](#)

[Links](#)

[Terms and Conditions](#)

[Contact](#)



Тэгээд л одоо улирлын амралтаар нэг хүргээд л ирнэ, тэгээд хүргэж ирнэ тэгээд дахиад улирлын амралт дуустал бол эргэж ирэх тухай асуудал байхгүй. Тэр ч байтугай одоо бид нарын чинь эцэг эхчүүд суман дээр ирж авдаггүй байлаа шүү дээ. Баг, баг дээр нь машинаар хүргэж өгдөг. Бригад, бригад дээр нь тэгээд бид нар чинь 53-ын орой дээр л одоо тэр Өгөөмөр бригадын хүмүүс гэвэл тэгээд л тэр машины орой дээр чинь суучихна. Тэгээд л нөгөөх чинь нэг хэсэг нь бөөлжинө, огино тэгээд л тэр бригад дээр очоод, бригад дээрээс одоо аав, ээж нь ирээд авдаг, тэгээд л нэг мотоцикльд чинь одоо бид нар чинь одоо нэг 5-6 хүүхдийг нэг мотоцикл сундалж явдаг байлаа шүү дээ. Тэгээд заримдаа ингээд нэг 10 км явж 2-3 хүүхдээ буулгачихаад л тэгээд л нөгөө хүүхэд нь явган гэр рүүгээ явж байна. Ахиад л хүрч ирж ингэж өртөөлж ингэж авдаг байлаа шүү дээ манай аав бол.

Оюунтунгалаг -

Тэгээд эргэлт бол ирүүлэхгүй, өөрсдөө ирэхгүй ч гэсэн эргэлт энэ тэр хүнс, хоол явуулах өвлийн цагт идэш ууш явуулах уу?

Сугир -

Үгүй үгүй, дотуур байранд бол тийм юмны шаардлага байхгүй. Ер нь тэр үед бол хоол унд үнэхээр хангалттай байсан.

Оюунтунгалаг -

Тэр үед бүх юмыг дотуур байрны хүнс хоолыг төрөөс даадаг байсан юм уу, ээж, ааваас чинь зохих норм ч гэдэг юм уу авахгүй түлш, унааны нэмэр энэ тэр авахгүй юу?

Сугир -

Байхгүй, байхгүй 100 хувь төрөөс дааж байсан. Хоол унд, тэгээд тэр байр, ус цас тэр л ариун цэврийн хэрэглэл одоо ерөөсөө бүгдийг нь. Зөвхөн хүүхэд бол өөрийнхөө хичээлийн хэрэглэл, цүнх хувцас хунараа л одоо ар гэр нь хариуцаж байсан.

Оюунтунгалаг -

Дотуур байранд дэг журам ямар байв. Одоо бас нэг арай ахмад ах насны дээр ангийн хүүхдүүд бас бие биенийгээ дээрэлхэх ч юм уу тийм юм байв уу ер нь?

Сугир -

Үгүй ээ бас одоо байна тэр чинь бол одоо 5, 6-р ангийн 7, 8-ийн хөвгүүд чинь бас нэг 2, 3-р ангийнхаа хүүхдийг бас нэг жаахан дээрэлхэх, ор дэрээ хураалгах бас ийм нэг аасар саасар юм байна. Гэхдээ тэд нар чинь хатуу, хэрвээ одоо ямар нэг байдлаар багш нар мэдэх юм бол бас өндөр шийтгэлд ордог байсан л даа.

Оюунтунгалаг -

Ер нь дотуур байранд байхад гэрээ санах уу, их санах уу ер нь ээж аавыгаа их санах уу?

Сугир -

Өө дан бага ангид байхад их санана. Одоо манай энэ хөшөө чинь бид нарыг сургуульд байхад байж л байлаа. Энэ хөшөөн дээр чинь тэгээд гараад нөгөө гэрээс одоо ирдэг машин зам энэ тэр чинь байна шүү дээ, нөгөө бригад руу явдаг зам, энэ зам энэ тэр чинь их гоё харагддаг байлаа л даа.

Оюунтунгалаг -

За /инээв/.

Сугир -

Тэгээд л яг нутаг усны ойролцоо байдаг тийм ах, эгч нар хөдөөний хүмүүс ирсэн байвал одоо бараг л гэрийн хүн ирсэнтэй адилхан юм шиг л одоо их сайхан харагддаг байсан.

Оюунтунгалаг -

Ээж, аавдаа захиа бичих үү?

Сугир -

Үгүй дээ, тийм юм байхгүй. Тэгээд л улирлаас улирлын хооронд л байх л юм чинь тэгээд амраад л гэртээ оччихно, тэгэхдээ хичээл их тасалдаг байлаа, тэгээд яахав зүгээр манай аав, ээж нөгөө нэгдлийн олон тэмээтэй байсан учраас нэг улирлын амралтаар яваад нэг 7 хоног нэг 14, 5 хоног тасалчих бол энүүхэнд байлаа.

Оюунтунгалаг -

Хэтэрч амардаг?

Сугир -

Тийм, хэтэрч амардаг. Тэгээд л одоо ирээд багш загнана, яанаа гээд ирнэ. Тэгээд л ээж сүү сайн өргөөрэй гээд тэгээд сүү өргөж байгааг нь харчихаад явахаар, ирэхээр багш нар чинь бас нэг их загнах нь бага ч байх шиг л энэ тэр л байдаг л байлаа шүү дээ. Би хичээл их тасалдаг байсан, тэр бол яахав аав, ээж хүргэж өгч чадахгүй, ажил нь амжихгүй, ингээд л таслуулаад зэмлэлд ордог байсан л даа.

Оюунтунгалаг -

Дотуур байрны багш нар гэж тэр үед ямар хүмүүс байв аа, одоо бас нэг ээж, ааваасаа хол байгаа хүүхдүүдэд одоо ер нь хэн нь байж чадах вэ?

Сугир -

Үгүй ээ яахав ээ, дотуур байрын багш нар гээд ахмад голдуу хүмүүс байсан л даа. Тэгээд тэд нар бол бас зааж сургана, тэгээд л бас их хариуцлагатай л даа, социализмын үеийн хүмүүс чинь бол одоо их хариуцлагатай л даа, тэр үүдний жижүүр эд нар бол жижүүр хийх л ёстой бол хийгээд л сууж байдаг, цэвэрлэдэг тэгээд өглөө орой дууддаг. Уралдаан тэмцээн зохион байгуулдаг, хүүхдүүдтэй их ажилладаг байсан юмаа тэр үеийн дотуур байрны багш, тэгэхдээ бол яг мэргэжлийн хүмүүс байгаагүй л дээ. Тийм ахмад тийм л одоо өндөр Гунгаа гээд л хүн байсан. Тэгээд одоо сүүлийн үед бол энэ залуучууд бас дотуур байрны багш энэ тэрээр их л ажиллах л юм. Тэгэхдээ янз бүрийн тэр чөлөөт цагийг нь зөв боловсон өнгөрүүлэх чиглэлээр тийм бодитой санаачлагатай ажиллаж байгаа юм тун харагдахгүй л байна л даа. Одоо бол бид нар дотуур байрын багш бол ер нь багш мэргэжлийн хүмүүс байх нь зүйтэй л гэж бодож байна.

Оюунтунгалаг -

Тэгээд дотуур байранд тэр үед одоо соёл хүмүүжлийн ажил янз бүрийн юм их зохиогддог байв уу?

Сугир -

Зохиогддог байсан, одоо тэгээд л хагас бүтэн сайн өдөр болгон одоо байранд чинь үдэшлэг уулзалт тасгуудын хооронд урлаг соёлын уралдаан тэмцээн гээд их олон арга хэмжээ болдог байсан.

Оюунтунгалаг -

Тэгээд дотуур байрны хүүхэд нөгөө гэрээсээ явж байгаа сумын төвийн хүүхдээс ч юм уу сумын төв дээр гэрээрээ ирсэн байгаа хүүхдүүдээс ялгарах уу ер нь ялгардаг байв уу?

Сугир -

Үгүй ээ яахав одоо хичээл сургалтын хувьд бол нэг их гадуур байрны хүүхэд дотуур байрны хүүхдээс нэг их илүү сураад байгаа нь ч нэг их харагддаггүй байсан л даа. Дотуур байранд ч гэсэн сайн сурлагатай хүүхдүүд зөндөө л байсан. Үнэхээр одоо хичээл хийх тэр нөхцөл боломжийг нь их л бүрдүүлж өгдөг байсан л даа. Тэгэхдээ яахав гэр орноо санахгүй байгаа учраас гадуур байрны хүүхдүүд бол арай дээр л байдаг байсан байх.

Оюунтунгалаг -

Та чинь айлын хэд дэх хүүхэд билээ?

Сугир -

Би чинь айлын 6 дахь нь.

Оюунтунгалаг -

Дээрээ нилээн олон ах, эгч бас дотуур байранд цуг байсан байна шүү дээ?

Сугир -

Аа яахав 5 ах, эгчээс надаас дээш нэг эгч нэг ах 2 л надтай хамт цуг сургуульд сурч байсан л даа, тэгээд л бусад нь дүү нар.

Оюунтунгалаг -

Тэд нар бас их дэм болно тийм ээ?

Сугир -
Тэгнээ тэгнэ.

Оюунтунгалаг -
Танай хүүхэд аав ээж одоо ах дүү нар чинь бол бүгд сургуулиар явсан уу?

Сугир -
Үгүй ээ яахав одоо ер нь дээд сургууль төгссөн хүн байхгүй л дээ. Би л нэг эчнээгээр төгссөн, одоо бусад ах, эгч нар бол одоо тэгээд л 8, 9 төгсөөд л бүр одоо бид нарын хамгийн том ах, 2 том ах, 1 эгч бол 4-р анги төгсөөд дандаа хөдөө гарчихсан. Энэ бол яахав гэхээр Манлай сум чинь бага сургуультай байсан, дунд сургуульдаа бол 5-р ангидаа нөгөө Цэций суманд очиж суудаг байсан учраас тэгээд хол одоо сургуульд явуулж чадахгүй гээд дандаа багаас нь гаргаж аваад тэгээд нөгөө мал маллуулах гээд ингэсэн.

Оюунтунгалаг -
Ээж, аав бол та хэдэд ер нь явахад чинь юу гэж захих вэ, сургуульдаа явахад чинь ер нь юу гэж сургадаг хүмүүс байв?

Сугир -
Үгүй одоо манай аав, ээж бол ёстой одоо насаараа л одоо мал малласан. Энэ нэгдэл нийгмийн төлөө л одоо ажилладаг хүмүүс байсан учраас тэгээд сайн онц авч байвал их л урамшуулдаг байсан, тэгээд үгээр их урамшуулдаг. Тэгээд ер нь манай аав ээж чинь хүүхдүүдээ нэг их тийм зодож жанчаад байна гэж байхгүй л дээ. Тэгээд тэр олон хүүхэд чинь тэгээд их олуулаа өссөн учраас аав, ээжийгээ их зовоож өссөн учраас одоо бол ер нь их л өрөвддөг юм даа.

Оюунтунгалаг -
Очихоор дүн юмыг чинь сонирхоно?

Сугир -
Сонирхоно.

Оюунтунгалаг -
Очоод тэр үеийн хүүхдүүд ер нь ээж, аав хүүхдүүдийн хоорондын харилцаа ер нь ямар байсан бэ, хир илэн далангүй байв?

Сугир -
Зүгээр дамаагүй малчид бол ер нь тэр хүүхдийнхээ тэр нэг сурлага юманд анхаарал тавих тийм боломж их муу байсан л даа. Асар их олон мал хариуцсан тэр одоо мал алдаж үрэгдүүлэх юм бол өр төлбөрт ордог байлаа шүү дээ, тэр чинь одоо хүний л юм чинь дээ тийм ээ. Тийм учраас одоо хүүхдүүдээ гэр орноо санаж байгаа байх гээд л нэг 10-20 хоноод нэг сар болоод ч юм уу эргээд ирэх тийм боломж нөхцөл байсангүй л дээ. Тэгээд яахав зүгээр энд нь одоо дотуур байр энэ тэр бол хоол хүнс хамаг юмных нь хувьд хангамж сайн байсан учраас л хамгийн гол нь хүүхдүүд аав ээжээ, бага насны хүүхдүүд нилээд сансанаас болж тийм бүрэн дүүрэн сурахгүй байх тохиолдол бол байсан байх.

Оюунтунгалаг -
Ер нь бол амралтаараа очоод ээж, аавдаа тайлагнах уу, тэгж сурлаа, ингэлээ, тийм юм үзлээ, тийм байлаа ингэлээ тэглээ гээд ээж аав нь ч гэсэн асууж энэ тэр тэгэх үү?

Сугир -
Ямар авав гэдэг бол тэр чинь бол онцгой л доо, тэгээд л очингуут л асууна, тэгээд л одоо онц сайн авсан хүүхдүүд бол нүүр бардам л хэлнэ. Тэгээд муухан авсан хүүхэд нь бол сулхан дуугардаг л байсан байх.

Оюунтунгалаг -
Тэгэхээр одоо дотуур байранд та хэллээ шүү дээ, ор дэрээ хураалгадаг арай бас бага насныхныгаа дээрэлхэх ч юм уу тийм хүүхэд байсан гэж тийм ээ, сургуульд бол тийм юм байв уу ер нь атаман, таны үеийн чинь атаман, овгор одоо юу гэдэг юм тийм хүүхдүүд байв уу?

Сугир -
За ер нь учиргүй одоо тэр хүүхдүүдийн мөнгө төгрөгийг дээрэмддэг, учиргүй их зоддог нүддэг юм бол нэг их байгаагүй шүү ер нь бол, зүгээр бага 1, 2, 3-р ангид байхдаа бас одоо тийм бусдаас илүү хүч чадалтай ер нь илүү сайхан хувцасладаг одоо тэр үедээ бид нар сургуулийн овгор гэж боддог хүүхэд байсан. Тэгэхдээ одоо тийм хүмүүжилгүй, тэр хүүхэд шуухдуудыг хамаа намаагүй зоддог, нүддэг, архи дарс уудаг тийм танхай юм бол манай сургуульд нэг их байгаагүй дээ, ер нь гайгүй.

Оюунтунгалаг -
Тэр үед сургуулиас бусад газар ямар нэгэн боловсрол эзэмших боломж байв уу, байв уу тийм юм ер нь, сургуулиас бусад газар?

Сугир -
Байгаагүй дээ. Одоо ерөөсөө ганц л ЕБС, сургуульдаа л эзэмшихээс өөр юм хувийн юм гэж байсан биш тийм ээ, тийм юм байхгүй.

Оюунтунгалаг -
Тэгээд тэр үед одоо сургуулиас өөр газар ямар нэгэн дугуйлан секц хичээллэдэг ч юм уу янз бүрийн сургалтууд энэ тэр зохиогддог байв уу ер нь?

Сугир -
Байхгүй ээ, ер нь одоо сургууль дээрээ л юм зохион байгуулна уу гэхээс биш өөр одоо бусад ер нь ямар нэгэн уралдаан тэмцээн юм байхгүй дээ, ер нь байхгүй. Зүгээр яахав сумын соёлын төв бол тусдаа энэ соёлын төв чинь одоогийнхоос хамаагүй сайн ажиллаж байсан шүү дээ. Бүр одоо хөдөөний малчин айлуудаар ингээд тэмээн тэргэнд одоо тэрэг хөлөглөөд тэгээд одоо тоглолт хийгээд ингээд явдаг байлаа. Малчдад номын сангаар үйлчилдэг байлаа шүү дээ, энэ номын сангаар чинь одоо малчдад ингээд номоо тараагаад ингээд тэд нар завсар чөлөөндөө зарим нь номоо уншдаг л байсан байлгүй дээ, одоо бол энэ соёлын төвийн үйлчилгээ бол төсөв хөрөнгөндөө захирагдаад зөвхөн нэг сумын төв дээр үлгэн салган үйл ажиллагаа явуулдаг л юм болж хоцорлоо л доо, тэр малчдад бол урлаг соёлын үйлчилгээ үзүүлэх одоо ямар ч боломж алга, төсөв хөрөнгөндөө баригдаад.

Оюунтунгалаг -
Та өөрөө бага байхад чинь одоо таныг бага байхад хамгийн гоё жүжиг, кино, театр ч юм уу юу байсан бэ ер нь, хамгийн анх ямар кино үзэж байв, сэтгэлд хоногшсон ямар тийм кино жүжиг юм уу юу байв ер нь?

Сугир -
Үгүй яахав ер нь бол бид нарын чинь одоо сургуульд байхад дамаагүй дотуур байранд энэ тэрд байхад бол ер нь байраар нь энэ тэр ингээд дэлгэцийн кино их л гардаг байсан л даа. Тэгээд би болохоор бас тийм нэг их кино шүлэг сонирхоод байдаггүй байлаа ерөөсөө, тийм, үзвэр үйлчилгээнээс ер нь жаахан хол тийм хүүхэд байсан, кино сайн гарч байсан, дэлгэцийн кино бол их гардаг байсан шүү дээ.

Оюунтунгалаг -
Сургуульд ямар хувцас өмсөх вэ, тэр үед чинь одоо форм?

Сугир -
Форм өмсөнө, яг нэгдсэн одоо манайх чинь дандаа хилэн форм өмсдөг байлаа шүү дээ, бор хилэн. Эмэгтэй хүүхдүүд нь бол дандаа нөгөө хүрэн өнгийн тийм форм өмсдөг байсан, тийм, бүгд ижил, тэгээд галстукаа зүүнэ, тэгээд нөгөө захны манжетка даавуутай.

Оюунтунгалаг -
Сургуульд байхдаа янз бүрийн одоо байгууллагын гишүүн байв уу, одоо пионер ч гэдэг юм уу, тэр эвлэл энэ тэр ч байл уу тийм ээ, гишүүнд элсэж байв уу, ямар санагдаж байв ер нь?

Сугир -
Элсэж байсан, бид нар ч одоо пионерын гишүүн болж нөгөө тангараг өргөж энэ чинь бол их сайхан зүйл байлаа шүү дээ. Пионерын гишүүн байлаа. Тэгээд яахав нөгөө дотуур байр энэ тэрд бол байрын зөвлөлийн гишүүн мишүүн гээд ийм олон нийтийн сонгууль юм зөндөө л байсан л даа.

Оюунтунгалаг -
Эвлэлд элсэж байсан байх тийм ээ?

Сугир -

Эвлэлд чинь бид нар чинь нөгөө 8-р ангиа төгсөөд элсдэг байсан билүү? Ингэхэд 16-тай байхдаа элсдэг байл уу, 18-аас элсдэг байлуу ямарч л байсан элсээд эвлэлийн хурал, эвлэлээс зохион байгуулж байгаа юманд бас нилээд идэвхтэй оролцдог байлаа л даа.

Оюунтунгалаг -

Ер нь бол тэр үед чинь ангийн дарга маргаасаа хүүхдүүд айж эмээх үү?

Сугир -

Эмээдэг байсан дамаагүй намайг Цэцийд 9-р ангид байхад бол тэр байрын зөвлөлийн дарга Байгалмаа гээд одоо 1-р сургуульд химийн багшаар ажиллаж байгаа Улаанбаатар хотод, тэр хүүхдээс бол тэр дотуур байрны тэр эмэгтэй хүүхдээс дотуур байрны бүх хүүхдүүд айдаг эмээдэг, хэлсэн ярьснаар нь байдаг байлаа шүү дээ, хатуу шаардлага тавьдаг.

Оюунтунгалаг -

Тэгээд таны хүүхэд нас ер нь бусад хүүхдүүдээс юугаараа ялгаатай вэ?

Сугир -

Одоо бид миний хүүхэд нас бол яг л одоо малчдын хүүхэд л ямар л үе туулдаг вэ, ямар л үйл ажиллагааг дамждаг вэ одоо яг тийм жамаар л явж ирсэн. Тэрнээс биш одоо бусдаас нэг онцгой сайн онцгой муу юм бол байхгүй л дээ. Тэгээд л одоо тэр нэгдэлд одоо дан тэмээ маллаад л бид нар чинь одоо тэгээд амралтаараа аав, ээждээ туслаад л тэр тэмээгээ уславал услаад маллаад л тэмээгээ унаад хариулаад л ингэж л одоо өссөн л дөө. Манай аав ч бас яахав нэгдэлд олон жил үр бүтээлтэй ажилласны үр дүнд улсын аварга малчин болж байлаа. Монгол улсын гавъяат нэгдэлчин болж байлаа, тэр үед чинь яахав өрхийн тэргүүн гэдгээрээ тэгээд өрхийн тэргүүн нь шагнагдаад л яваад байдаг. Гэр бүлийн хүн нь бол одоо тэгээд нэг тийм дайвар туслагч юм шиг л байдаг байлаа л даа. Одоо харахад бол ер нь хамгийн их ажлыг одоо манай ээж л амжуулж байж л дээ. Тэр олон хүүхдийг бүх хувцасыг оёдог, тэр айлын л одоо бүх тогоо шанагыг хөдөлгөдөг, тэгээд л тэр ингэ, мал, сүү, цагаан идээ хамаг юмыг нь л борлуулдаг. За аав бол яахав одоо хүнд хүчир ажлыг нь амжуулаад унаа унаад тэгээд л одоо малын бэлчээрт л явдаг хүн байж дээ.

Оюунтунгалаг -

Хэн нь одоо илүү их малчин гээд тооцогдоод тэгээд юу яана гэдэг юм уу эсвэл өрхийн тэргүүнээрээ голчлон тооцогдоод тийм ээ?

Сугир -

Өрхийн тэргүүнээрээ тооцогдоод.

Оюунтунгалаг -

Тэгээд одоо цаана нь бол гэр бүл л шагнал одоо тэр хөдөлмөрийг эрхэлж байгаа шүү дээ ерөөсөө, тэр малыг?

Сугир -

Тийм.

Оюунтунгалаг -

Ганц өрхийн тэргүүн тэр шагнал аваад байгаа хүн ганцаараа тэр малыг хариулна, өсгөж үржүүлээд байх биш тийм ээ?

Сугир -

Тэгээд шагналынх нь нэр нь л одоо өрхийн тэргүүн дээр явах болохоос биш, тэр авч байгаа мөнгөн шагнал одоо бусад юм чинь бол тэр өрхийн л одоо бүх хүмүүст л хэрэг болоод л явж байгаа л даа.

Оюунтунгалаг -

Тэгэхээр та хэлсэн шүү дээ, танай ээж, аав нэгдлийн малчин байсан гэж, ээж аав чинь ярьдаг уу ер нь нэгдэлжих хөдөлгөөн танай аймаг суманд хэзээ эхлэв, яаж элсэж орж байв, ер нь тэр үеийн нэгдэлжих хөдөлгөөний талаар ер нь юу гэж ярьдаг байсан?

Сугир -

Үгүй яахав одоо манай аав, ээж бол 1959 онд л нэгдэлд элссэн, ийм л хүмүүс байдаг, тэгээд өөрсдийнхөө хэд гурван малыг нийгэмчлээд л тэгээд нэгдлийн мал маллаад л явсан, тэгэхдээ манай аав, ээж бол нэгдлийг ерөөсөө харааж зүхэж байгаагүй. Тэр үеийн одоо яг нийгэм нь тийм байсан болохоор одоо тэгээд нэгдлийг бол муу зүйл байсан юм, бид нарын хөдөлмөрийг сорж байсан юм энэ тэр гэж ерөөсөө муу хэлж байхыг нь бол би сонсож байгаагүй, тийм. Тухайн үеийн юм тухайн үедээ болдог ороо л болсон, тэгээд л тухайн үеийнхээ цаг үеийг дагаад л одоо амьдарсан ийм л улс байдаг, тийм.

Оюунтунгалаг -

Ээж, аав чинь ер нь соёлын довтолгооны тухай ярьдаг байв уу, соёлын довтолгоон гэж ер нь юу байв, өөрөө ер нь тэр тухай юу мэддэг вэ?

Сугир -

Би ер нь одоо тэр талаар нэг их юм сонсоогүй шүү дээ ерөөсөө.

Оюунтунгалаг -

За.

Сугир -

Сайн ч мэдэж байгаа юм алга, зүгээр. Тэр соёлын довтолгооны талаар манай аав, ээж нэг их яриад байдаг юм байдаггүй, тийм. Ер нь бол соёлжуулах гэж үзэж байсан юмнууд бол бий л юм байна л ээ. Ядаж л бид нарыг чинь сургуульд байхад одоо айл болгоныг одоо гоожуур угаалтууртай болгоно, 2 одоо солих цагаан ээлжийн юу цагаан хэрэглэлтэй болгоно энэ тэр гээд л шаарддаг, шахдаг юм зөндөө л байсан л даа. Соёлын довтолгооны талаар сайн мэдэх юм алгаа ер нь.

Оюунтунгалаг -

Тэгвэл ингээд эргээд бодож байхад таны амьдралд гүн гүнзгий одоо нөлөөлсөн ямар үйл явдал байдаг вэ?

Сугир -

Үгүй одоо хамгийн том юм нь бол яахав би 9 настай сургуульд сууснаасаа болоод тэгээд 10-р ангиа төгсч чадалгүй тэгээд цэрэгт явсан. Цэрэгт явна гэдэг бол цэрэгт явснаараа тэгээд л ер нь одоо тэгээд амьдрал орвонгоороо л өөр боллоо л гэж ингэж л ойлгож байгаа л даа. Би цэрэгт яваагүй байсан бол 10-р ангиа төгсөөд ямар нэгэн сургуульд явна. Тэгээд цаашаа цэрэгт ер нь хэзээ явах ч юм уу үгүй ч юм уу тэгээд сургууль төгссөн бол одоо нэг тодорхой мэргэжил эзэмшээд ингээд л явах л байсан байх, тийм. Тэгэхээр одоо миний амьдралыг ер нэг 180 градус эргүүлсэн юм болов уу цэрэгт явах явсан явдал л гэж л ингэж л ойлгодог.

Оюунтунгалаг -

Төгсөөгүй байхдаа, сургуулиа төгсөөгүй байхдаа ухаандаа багш нарынхаа оронд л явсан байна шүү дээ?

Сугир -

Тийм, 10-р ангиа төгсөж чадаагүй ингээд цэрэгт явснаа бол одоо миний амьдралыг орвонгоор нь өөрчилсөн гэж ийм л одоо сайн ч байж мэднэ, муу ч байж мэднэ нэг ийм л үйл явдал болсон л гэж боддог, тийм.

Оюунтунгалаг -

Таны амьдралд ер бусын бусдаас онцгой гэх зүйл бий юу?

Сугир -

За нэг их тийм онцгойроод байх юм их байхгүй дээ, одоо ер нь учир зүггүй одоо онцгойлоод байх юм алга даа.

Оюунтунгалаг -

Танд ер нь дурсгалтай эд зүйл байдаг уу, хамгийн дурсгалтай ямар эд зүйл байдаг вэ?

Сугир -

За яахав одоо сургуульд байх үеийн альбом байна, одоо сурагч үеийн одоо альбом, цэрэгт одоо байх үеийн альбом, цэргээс одоо халагдахад өмсөж ирсэн хувцас, тэр үед чинь одоо халагдах хувцас гэж бас их сонин юм байлаа шүү дээ.

Оюунтунгалаг -

За.

Сугир -
Халагдахдаа өмсөж ирсэн хувцас ингээд одоо нэг биетээр бол ийм л зүйлүүд байна даа.

Оюунтунгалаг -
Цэрэг гэснээс ер нь цэрэгт ямар байв, одоо та чинь цэрэгт хэдэн жил алба хаав?

Сугир -
3 жил алба хаасан.

Оюунтунгалаг -
Тэр үе чинь одоо өнөөдрийн яригдаад байгаа цэргийн дэглэлт, тийм юм ер нь байв уу?

Сугир -
За яахав ер нь социализмын үед бол цэрэгт бол тэр дэг гэдэг юм байсан юмаа, тэр бол ерөөсөө гарцаа байхгүй байсан юм. Тэгэхдээ ардын цэрэгт их байсан гэж би сураг сонссон, хилийн цэрэг бол харьцангуй гайгүй, дамаагүй одоо социализмт нийгмийн үед хилийн цэрэг бол маш өндөр хангамжтай, хилийн цэргийхэн бол дандаа хонины мах иддэг л тийм л хүмүүс гэж ойлгогддог байлаа. Тэгээд тэр үеийн одоо хүүхнүүд ч гэсэн хилийн цэргийн офицеруудтай суух гэж ч бас их яадаг байсан гэж сонссон, тэгэхээр хилийн цэрэг бол бас их сайхан алба л даа. Тэгээд тэр үед бол хангамж ч өндөртэй, их нэр төртэй, тэгээд бас одоо нилээн цэргээс чинь бас нэг боловсрол одоо тэгээд юм юмаар нь бас жаахан шилж сонгож хилийн цэрэгт хуваарилдаг байсан байх гэж ингэж би боддог юм. Цэрэгт бол яахав тэгээд би бол бас шинэ цэрэг очоод л тэгээд л шинэ цэргийн каринтин дуусгаад л бага даргын курс гээд тийм юманд орсон л доо. Тэгээд тэнд 1 жил болоод тэгээд 2 жил ангийн дотоодын харуул хамгаалалтанд ажилласан, хилийн цэрэгтэйгээ онц хилчинээр 1 шагнуулсан, ахлагч цолтой халагдсан. Үгүй яахав цэргийн 3 жил бол яахав албаа одоо бусдаас онцгой биш ч гэсэн гайгүй нэр төртэй хаасан л гэж боддог.

Оюунтунгалаг -
Тэр үед ч одоо хилийн цэрэгт хил дээр эргүүл, харуул хийнэ тийм ээ?

Сугир -
Тийм.

Оюунтунгалаг -
Тэр хил дээр янз бүрийн зөрчил будлиан гардаг байв уу, хил зөрчих тохиолдол ер нь олон байв уу?

Сугир -
За ер нь нэг их гарч байгаагүй ээ. Манайхаас бол яахав нэг шоронгоос оргоод олон жил болсон Шаазанхүү гээд нэг нөхөр манай одоо хилийн заставын нутгаар монголоос одоо гадагч нь оргох тийм нэг оролдлого хийсэн. Тэгээд тэнд бол асар их сүр дуулиан болж нисдэг тэрэг мэрэг хотоос ирж эрэл хайгуул болж ингээд л барьж аваад явсан л даа. Тэгээд ер нь Овоотоор бол хятад талаас орж ирдэг хил зөрчигч нар ер нь ховор байсан, Хятадын хил зөрчигчийн гол нь энэ Сүхбаатар, Дорноговиос зүүн тийшээ хилээр хилийн зөрчигч нар их гардаг байсан, баруун талаар бол тун гайгүй. Тэгээд л яахав одоо хилийн манаанд явна. Хилийн манаач нар бол ийм зогон татсан тэгээд энэ дээр л мөр ул байна уу үгүй юу гээд л өвлийн улиралд тэмээгээ унаад л, зун нь бол явган яваад л ингэж л одоо үздэг л байсан л даа.

Оюунтунгалаг -
Тэр үед чинь бол хил давж мал энэ тэр гарах тохиолдол их байх уу?

Сугир -
За гайгүй дээ ер нь дандаа нөгөө нэг нэгдэл нийгмийн мал хариулга маллагаа ихтэй байсан учраас тэр болгон одоо манай мал хил даваад явчихаж гэнэ, хятадын талаас мал нэг их ороод ирчихэж гэнэ гэж одоогийнхийг бодвол бага байсан.

Оюунтунгалаг -
Ан амьтан бас л ялгаагүй юу?

Сугир -
Ан амьтан бас л ялгаагүй, тэгээд ер нь баруун талаараа ер нь торгүй байсан л даа, зүүн талаараа сүүлд тор татсан. Хилийн дагуу тэгээд мал зал наашаа цаашаа их гардаг ордог болохоороо, баруун талаар бол ер нэг их нь мал, хил зөрчигч аль аль нь бага байсан учраас тэгээд тор татаагүй, одоо ч татаагүй байгаа.

Оюунтунгалаг -
Тэгээд тэр хилийн застав нь юу одоо хүртэл байгаа тийм ээ?

Сугир -
Байгаа, одоо манай хилийн 163-р анги гээд хилийн отряд байж байгаа.

Оюунтунгалаг -
Та тэгээд одоо цэргээс ирснийхээ дараагаар ер нь хэзээ гэр бүл болов, ер нь социализмын үед гэр бүлийн талаар төрөөс ямар бодлого баримталж байсан бэ ер нь, тэр нь хир нөлөөлж байв өөрийн чинь гэр бүлд?

Сугир -
Үгүй яахав социализмын үед чинь одоо хүнээ өсгөх гэж их үзэж байлаа шүү дээ. Одоо олон хүүхэдтэй эх чинь эмэгтэй, эхчүүдэд маш их мөнгө өгдөг байлаа, хүүхдийнх нь тоогоор. Тэгээд манайх чинь одоо ер нь манай суманд нэгдлийн мал маллаад авсан хөлс, цалингаараа бол яахав одоо тэгээд нэг өмсөж, зүүх, идэх энэ юмандаа л таардаг байсан байх. Олон хүүхэдтэй айлууд бол олон хүүхдийнхээ мөнгөөр мотоцикл авч унадаг байлаа. Ер нь тэр үед социализмын үед чинь бол олон хүүхэдтэй айл л арай нэг мотоцикл энэ тэр авч унах чадвартай байдаг байлаа л даа. Тэгэхээр одоо хүн амаа цэвэр цусаар нь өсгөхийн тулд бол төрөөс асар их анхаарч байсан гэж ингэж ойлгодог, зүгээр гэр бүлийн хувьд бол айл өрх боллоо гэж одоогийнх шиг нөгөө 500.000 төгрөг өгнө энэ тэр гэдэг шиг тийм ч юм байгаагүй л дээ. Яахав зүгээр нэгдлээс бол үнэхээр салхи, шуурганд одоо гэр бараагаа эвдсэн, түлэгдсэн тэгээд иймэрхүү хүмүүстээ бол нөгөө нэгдэл чинь өөрөө хөрөнгөтэй газар учраас тус дэм болдог байсан л даа, тийм айлууддаа бол арга хэмжээ авдаг байсан.

Оюунтунгалаг -
Одоо тэр үед юу гэдэг юм нэгдлийн гишүүд нь хоорондоо гэрлэх гэр бүлүүд гарах юм бол юу гэдэг юм хурим найрыг нь хийдэг ч юм уу тиймэрхүү гэр бүлийг хөхүүлэн дэмжих зорилгоор явуулж байсан тийм бодлого ер нь байдаг юм уу?

Сугир -
За даа нэг их байхгүй дээ, яахав зүгээр нэгдлийн гишүүд гэж чинь одоо сумын хэмжээний бүх малчид чинь нэг л нэгдлийн гишүүн байсан юм чинь дээ. Зүгээр яахав одоо нэгдлийн ой мой энэ тэр гээд бол малчдаа бас баярлуулдаг, цуглаж баяр наадам хийдэг юм бол байсан, сумын наадам энэ тэрийг бол байнга хийдэг л байсан л даа, тэр ч байтугай 9 сарын 1-нд сургууль цуглахад дандаа 100 даагийн уралдаан гэж зохион байгуулдаг байлаа шүү дээ. Хүүхдүүд нөгөө зуны амралтаар очоод унасан даагаа авчиралд тэгээд уралдуулдаг, бүр ийм уламжлалтай байсан. Тэгээд нэгдэл байхад чинь нөгөө малаа сайн малласан залуучууд чинь гадаад дотоод их явж байлаа шүү даа.

Оюунтунгалаг -
Өө ээ.

Сугир -
Тийм, бүр нэгдэл байхад чинь үйлдвэрчний шугмаар, эвлэлийн одоо шугмаар, тэгээд нэгдлийн шугмаар дотоодынхоо одоо үзэсгэлэнт Халх голоор ингээд л үзэсгэлэнт байгалиар аялах одоо тийм шагналууд их байлаа шүү дээ. Тэгээд тойрон аялалаар ингээд сум болгоноос нэг нэг залуучууд ингээд аймгийн хэмжээнд цуглараад явдаг юм уу эсвэл улсын хэмжээнд нэг аймгаас 5, 5 хүн очоод ингээд явдаг ч юм уу ийм юм их байлаа. Мөн тэргүүний ажиллагаатай тийм залуу эрэгтэй, эмэгтэй хүмүүсээс чинь одоо ОХУ-д энэ тэрд айлчлаад ингээд аялаад хүмүүс одоо ч зөндөө байгаа. Одоо манай Баатарбанди гуайн тэр Жаалхүү гээд л явж байсан, Баажий гээд эмэгтэй явж байсан, Оюунчимэг гээд ингээд л явж байсан. Социализмын үед бол ажил сайн тийм залуучуудыг, тийм хүмүүсийг газар нутаг үзүүлэх тийм аялал гадаад дотоодын юманд бол их явуулдаг байсан. Одоо 90 оноос хойш бол манайхан чинь одоо бол хувиараа л мөнгөтэй нь л ядаж одоо дотоодынхоо байгалийн сайхнаар явна уу гэхээс биш тийм албан ёсоор улсаас зохион байгуулаад гадаад, дотоод явуулж байгаа юм байхгүй байна л даа. Одоо яваандаа эрх биш болох байгаа даа л гэж.

Оюунтунгалаг -
Тэрнээс өөр замаар ер нь жирийн хүмүүс гадаад тэр улс орны хүмүүстэй ч гэдэг юм уу гэр бүлээрээ найзалдаг ч

юм уу тийм, нөхөрлөдөг ч юм уу тийм юм ер нь байв уу, гадаад орнуудын хүмүүстэй ч гэдэг юм уу ер нь яаж харилцдаг байсан бэ одоо цаашид яах вэ?

Сугир -

Гадаад талын харилцаа бол ер нь тийм гадаад талын юм бол байхгүй. Одоогийнх шиг ийм жуулчин, муулчин энэ хил мэл ингээд гадаад паспорт масторттой болоод ингээд яачихаагүй байсан болохоороо тэр үед малчид тэр дундаа тэр дундаа энэ хөдөө сумын хүмүүс гадаад дотоод холбоо тогтоох боломж байгаагүй л дээ. Аа зүгээр харин социализмын үед бол гадаад, дотоодын их дээд сургуульд бол шударгаар өрсөлдөж ингэж явдаг байлаа шүү дээ. Одоо манай сумаас гэхэд чинь 90 оноос өмнө ОХУ, Болгар, энэ Сервийн орнуудад сурсан хүмүүс их олон байдаг шүү дээ. 90 оноос хойш өнөө болтол одоо яг албан ёсоор одоо өрсөлдөөд ингээд гадаадад сургуульд төгссөн, боловсрол эзэмшсэн хүн Манлай суманд нэг ч алга, энэ 18 жил бол одоо боловсон хүчин үнэхээр тасалдчихлаа л даа.

Оюунтунгалаг -

Гадаадад тийм ээ?

Сугир -

Тийм, гадаадад сурсан хүн бараг нэг ч алга. Тэгээд одоо шударгаар өрсөлдөөд явдаг юм байхаа больсон, мөнгөтэй хүмүүс л тэр одоо гадаад дотоодын их дээд сургуульд сурдаг болсон, тэрнээс биш одоо яг тархиараа өрсөлдөөд конкурсээ өгөөд тэгээд энэ хамгийн өндөр оноотой байна, энийг одоо Орост явуулна, энийг Америкд явуулна гэдэг юм байхгүй одоо болчихож л дээ, зүгээр мөнгөтэй хүмүүс л явж байдаг. Тэрнээс бол яг тархиараа ингээд сурсан юмаараа өрсөлдөөд ингээд явах юм бол бас манай сумын хүүхдүүд, хүмүүсийн оюуны потенциал муугүй л гэж бодоод байдаг юм.

Оюунтунгалаг -

Та өөрөө гадаад их явж байв уу?

Сугир -

Үгүй ээ, социалист нийгмийн үед бол явж байсангүй.

Оюунтунгалаг -

За.

Сугир -

Тийм зүгээр яахав сая бол яахав энэ жил манай аймгийн иргэдийн хурлаас зохион байгуулаад аймгийн иргэдийн хурлын төлөөлөгч нар Сингапур, Малайз явуулж туршлага судлуулсан л даа, өөр газар яваагүй ээ. Энэ Хятадад бол явж л байдаг юм.

Оюунтунгалаг -

Ер нь социализмын үед гадаадын хүмүүс, мэргэжилтнүүд байдаг юм уу ажил албаны шугмаар ч байдаг юм уу эсвэл гадаадын ямар нэгэн байгууллага ч юм уу танай орон нутагт ажиллаж байв уу, тийм хүмүүс ирж байв уу?

Сугир -

Үгүй ээ одоо социализмын үед чинь нөгөө цэргийн ангиуд л их байлаа шүү дээ.

Оюунтунгалаг -

За.

Сугир -

Орос цэргийн ангиуд л одоо их байлаа, манай суманд ч орос цэргийн ангийн лакатарын анги байсан. Тэгээд л одоо энэ орос дэлгүүрээр нь манайхан ордог, одоо ийшээ ингээд Чойр, Дорноговь гээд л одоо оросын цэргийн анги бол маш их, тэгээд тэр орос дэлгүүрээс чинь бараа авах гэж бид чинь эндээс мотоцикльтой энэ тэр давхидаг байлаа шүү дээ, очоод оруулдаг. Тэгээд их сайхан бараатай, хямдхан тийм л байсан л даа. Тэгээд цэргийн ангид ч бол яахав монгол цэргийн ангид ч байсан дандаа орос зөвлөхүүд байлаа шүү дээ. Тэгэхдээ орос зөвлөхүүд бол одоо манай монгол дарга нараас л илүү одоо манай Макарав гээд манай Овоотын цэргийн орос зөвлөх байсан, өвлийн ямар ч хүйтэнд одоо тэр мотортой усны гадаа тэр ус гоожуулаад ингээд усанд шалдан ингээд ороод зогсож байдаг л ийм л хүмүүс л байсан л даа, тэгээд тэр бас орос зөвлөхүүд бол бас биеэрээ их үлгэрлэн манлайлагч нар их байдаг байсан л гэж боддог.

Оюунтунгалаг -

Тэр үеийн орос цэргийн ангийнхантай ч юм уу одоо орос цэргүүдтэй нутгийн ард түмэн яаж харилцдаг байв, харилцаа нь ер нь ямар байв?

Сугир -

Үгүй ээ ер нь энэ манай сумынхан лав дамаагүй одоо энд байсан орос цэргийн анги руу их л ирж очдог, тэгээд л одоо сумын зарим залуучууд зарим удирдлагууд энэ тэр их л найз нөхөд болсон л байдаг байсан шүү дээ.

Оюунтунгалаг -

За.

Сугир -

Тийм, тэгэхээр цэргийн анги гээд л бас яг тийм сүрхий хаалттай бүс байгаагүй байх, ямар ч гэсэн удирдлага энэ тэр нь бол энэ орон нутгийн хүмүүстэй уулзаад учираад яваад байдаг байсан юм шиг байгаа юм. Цэрэг нь бол гадуур дотуур тэнэх тухай асуудал байгаагүй байх л даа. Тэгээд манайд чинь орос монгол 2 цэргийн ангитай байсан л даа. Нэг дороо байсан.

Оюунтунгалаг -

Тэр үед одоо ер нь нутгийн хүмүүс цэргийн хүмүүст яаж ханддаг байсан бэ?

Сугир -

Үгүй ээ цэргүүдэд бол ер нь тийм таагүй ханддаггүй л байсан шүү дээ. Ер нь бол цэргүүд чинь бол бас шаардлагатай үед ингээд нөгөө малын халдвартай өвчин мөвчин гарах үед тэмээ чинь бол өөрөө тэмээн туулгалт ам руу нь эм хийхийн тулд л тэр чинь 2-3 хүн хэрэгтэй шүү дээ. Нөгөөхийг чинь ороож унагана, 2 хүн нэг нь толгойг нь бариад зогсож байна, тэгээд унагаад ам руу нь нөгөө нэг туулгалтын ногоон эм энэ тэрийг хийдэг. Тэгээд орон нутагт бол тийм ажил энэ тэрд нь цэргийн анги их тус болдог байсан. Тэгээд л энэ бүтэн сайн өдөр энэ тэр соёлын төвд цэргүүд нь ирж бүжиг танц зохиодог. Тэгээд ер нь Манлай сумын цэргийн ангиас манлай суманд хүргэн орсон хүн их олон байдаг шүү дээ.

Оюунтунгалаг -

Өө за өөр нутгийн тийм ээ?

Сугир -

Тийм.

Оюунтунгалаг -

Энэ чинь одоо Манлай сумын цэргийн ангид чинь Манлайн залуучууд цэрэгт ер нь алба хаах уу, дандаа өөр газраас ирэх үү?

Сугир -

За ихэнх нь өөр газраас ирж байсан даа, Манлайгаас их цөөхөн л хүн алба хаасан байх.

Оюунтунгалаг -

Тэгээд орос цэргийн анги ч гэсэн бас одоо тэр байгалийн хүнд хүчир нөхцөлд нутгийн ардуудад тусалж юм уу тийм талаар бас?

Сугир -

Орос цэргийн ангийг би одоо сайн мэдэхгүй байна. Ямар ч байсан монгол цэргийн анги бол их л тусалдаг байсан.

Оюунтунгалаг -

Орос цэргийн ангиуд тэр зөвхөн цэргийн ангийнхандаа зориулсан худалдаатай тийм ээ орос дэлгүүртэй байсан.

Сугир -

Тийм байсан, тэгээд.

Оюунтунгалаг -

Орос бараанд, ер нь монголчууд орос бараанд дуртай байсан тийм ээ?

Сугир -
Тэгсэн, тийм.

Оюунтунгалаг -
Ухаандаа тэр цэргийн ангиар дамжуулаад гадаад бараа, гадаад орны эд бараа их хэрэглэдэг байжээ дээ нутгийн ард?

Сугир -
Тэгсэн, тэгээд л тэр социализмын үед чинь одоо хүн хэдэн төгрөг л байна хармаандаа байгаа мөнгөөр би дэглүүрт очоод юу авах вэ гэдгээ тэр дэглүүрт орохоосоо өмнө бүгдийг нь одоо тооцох, товлонх бололцоо байлаа шүү дээ, 8-ийн торго, 9-ийн чихэр, 11.20-ын чихэр гээд за би одоо хармаанд байж байгаа 50 төгрөгөөр нэг кг 11.20-ын чихэр авна, нэг толгой өтөн авна, нэг шил архи авна гээд ингээд л ямар ч үнэ хөдөлгөөнгүй. Бүх бараа нь одоо үнээрээ нэрлэгдчихсэн ийм л байсан шүү дээ.

Оюунтунгалаг -
Одоо бол ?

Сугир -
Одоо бол зах зээлийнхээ юмаар л одоо орж очиж байж л одоо ямар үнэтэй юм, тэгээд одоо авах гэсэн юмаа одоо зарим нь авч чадна, зарим нь мөнгө нь хүрэхээ болиод авч чадахгүй тэгээд л.

Оюунтунгалаг -
Та өөрөө хэзээ гэр бүлтэй болов, яаж айл болж байв?

Сугир -
Би чинь ерөөсөөгөө яахав одоо энэ баг бригадад ажиллаад ер нь гэр бүлтэй болъё ч гэж нэг их бодоогүй юм болов уу тэгээд би чинь 31 хүрч байж одоо айл боллоо шүү дээ. Тэрнээс өмнө одоо хүн амьтантай сууж байсангүй, хүүхэд шуухадтай болж байсангүй. Тэгээд л нэгдэл нийгмийн ажлын төлөө л хоёр нарны хооронд л явж байсан.

Оюунтунгалаг -
Тэгээд ер нь тэр үед айл болоход хүндрэлтэй юм байв уу, одоо ямар эд хогшил ээж, аав хөрөнгө хувааж өгч байв уу, яав?

Сугир -
Үгүй яахав цэргээс ирсэн дараа л ээж, аав л нэг мотоцикль авч өгсөн. Тэгээд л тэр мотоциклийг л одоо баг бригадад л ажиллаад л одоо тэгээд л тэр үед чинь мотоцикль нь бензин л өгдөг сэлбэг запас өгдөггүй, тэгээд л одоо тэр мотоциклоор яахав одоо нэгдэл нийгмийн ажилд яваад л ингээд цагийг барж байсан даа, тэгээд яахав хажуугаар нь ан гөрөө их хөөцөлдөж байсан.

Оюунтунгалаг -
Ан гөрөө гэснээс энд чинь одоо ан их элбэгтэй байлаа тийм ээ, зээр гөрөөс энэ тэр их элбэгтэй байлаа, тэгээд сая замд ерөөсөө нэг ч ан амьтан тааралдсангүй шүү дээ санагдаад байх юм тэгээд ан ингэж их ховордов уу, тэгээд юунаас болоод ховордовоо?

Сугир -
Ер нь 90 оноос өмнө бол зээр энэ тэр чинь бол хэдэн зуугаараа сүрэлгээд л явдаг байлаа л даа. Тэгээд манай сумын ард түмэн бол энэ цагаан зээр гэдэг юмыг ерөөсөө иддэг ч үгүй хэрэглэдэг ч үгүй мах шөл нь шороо амтагдсан ер нь бузын амьтан гэдэг байлаа, энийг чинь ерөөсөө алдаггүй хэрэглэдэггүй байсан. Хар сүүлтээ бол их алж иддэг байлаа. Одоо бид нар чинь бол ер нь хар сүүлтийн махаар л хүн болсон улс шүү дээ. Одоо энэ Манлай сумын малчдын хүүхэд бол бараг л тэр зээрийн мах идэж л хүн болсон, маш их алж иддэг байсан. Тэглээ гээд цөөрөөгүй л юм даа. Тэгээд л одоо сүүлийн үед л 94-5 оноос л гэнэт л алга болсон. Энэ одоо зарим нь хятад руу зарим нь бол хил нэвтрээд гарахаар нь хятадууд бөөн цөөлөөр нь хашсан юм гэнэ лээ гэж ярьдаг юм. Тэгээд зарим нь ган зуд болсон үхсэн юм гэнэ лээ гэдэг юм. Ер нь бол гэнэт л алга болсон. Энэ жил одоо их олноороо байж байсан хойтон гэнэт л алга болсон, маш цөөхөн болчихсон. Нэг тийшээ нүүсэн л гэж боддог, аа тэрнээс бол үхсэн бол хүүр нь харагдана, тийм юм байхгүй. Тэгэхээр бол ан амьтныг бол учир зүггүй алаад хядаад бол барсан эд биш гэж бодоод байдаг юм. Нүүгээд л одоо тэгээд гадаадын орнууд руу гараад хашуулж бариад яачихав уу эсвэл нэг тийш нь нүүгээд энэ яахав хангай руу нүүж гарахаараа их хэмжээгээрээ алуулсан тохиолдол бий л дээ, тэгээд чоно, нохой одоо юмнууд ч бас элбэг л байсан л даа. Чоно ч одоо ч бас байна, тэгэхдээ ер нь ан бол бүх л чиглэлээрээ багассан л даа, тэгээд яахав учиргүй алаад багассан гэж би боддоггүй юм л зүгээр гэхдээ техник олширсон техникийн хүчээр бол алах юм ч бол байсан л даа. Урьд бид нарыг бага байхад бол тэмээ түлхэж алдаг байлаа шүү дээ, тэмээтэй морьтой тэгээд л нөгөө тэмээ мориныхоо хажуу талд хүн нь нуугдаад л ингээд тэмээ морио ээлжилж явсаар байгаад л тэнд идэж байгаа зээр гөрөөст ойрхон очиж байгаад бууддаг байлаа л даа, тэгж мотоциклоор элдээд хядаад байх юм ч бага л байсан л даа.

Оюунтунгалаг -
Тэгэхдээ тэр одоо агнаж идэх нь ер нь чөлөөтэй байсан юм уу, тийм зөвшөөрөлтэй байсан юм уу, эсвэл хориотой байсан юм уу?

Сугир -
Хориотой байсан тийм ерөөсөө алж болохгүй л гэдэг. Тэр үед чинь бол хуулийн байгууллага дарга нар нь бол ардуудаасаа нуугаад өөрсдөө алж иддэг, малчид ардууд нь бол дарга, цагдаа тэр хүмүүсээсээ нуугаад идээд л байдаг тийм л байсан.

Оюунтунгалаг -
Бүгд бие биенээсээ нуугдаад бүгд идээд байсан?

Сугир -
Тийм, бүгд л идэж байсан.

Оюунтунгалаг -
Тэгээд ан амьтан гэснээс ер нь ан амьтнаас гадна танай нутгийн байгальд ямар өөрчлөлт орж байна вэ ер нь?

Сугир -
Үгүй ээ тэгээд одоо зүгээр би л лав нөгөө тийм жаахан ажигч гярхай байдал ч одоо тийм муу байдаг ч юм уу зүгээр яг одоо бид нарыг бага байх үеийнх одоогийнх 2-той харьцуулахад бол зүгээр манай сумын хувьд бол учиргүй цөлжөөд одоо ер нь мал маллахад их хэцүү болсон гэж ойлгогддоггүй, бид нарыг бага байхад бол мөн л их ган зуд их болдог, хойшоо урагшаа хол ойр их нүүдэг үгүй одоо тэгээд л 80-аад оноос өмнө энэ тэр чинь бид нар их тэмээ хариулдаг байлаа. Энэ ширээ бөхтэй тэмээ л одоо огт байдаггүй л байсан шүү дээ. Тэр их цагдаж нөгөө их хариулга хашдаг болоод ч тэр байсан юм уу, одоо бол хавтгай тэмээ гэж бараг л үзэгдэхгүй болоод байгаа шүү дээ. Тэгэхээрээ яахав тэмээ ч гэсэн таваараа ингээд байхаараа идэш хоолондоо гайгүй ч байдаг юм уу бид нарын багад одоо ийм их урсгалтай булаг байсан одоо байхгүй болсон гэх юм яг миний хувьд бол тийм ийм юм бага л байгаа. Тэгээд л тэр баянбулаг миний л мэдэх баянбулаг, булаг шавартай гээд л зүүн урд Алагийн гол энэ тэр гээд л байдаг юмнууд бол бүгд л байж л байгаа, аа зүгээр урсгал нь арай багассан байж мэднэ, гэхдээ ер нь бол хатаж ширгээд сүйд болсон юм бол нэг их байхгүй л гэж бодож байгаа. Аа зүгээр цөлжилт гээд яриад байгаа зүгээр цаг агаартай л холбоотой гэж л бодож байгаа. Ер нь одоо энэ чинь одоо ногоо гарах нь өнгөрлөө гэмээр 2-3 жил ган зуд болоод л тэгээд шороо тавиад ингээд үндсийг нь ухаад хаясан байдаг шүү дээ, юу ч үгүй нэг бор үндэс ил гарсан байж байдаг. Аа тэгэхэд л үнэхээр их цаг сайжраад гараад ирэхдээ зэрэг л дамаагүй 93 он энэ тэрд бол 92 оны өвөл энэ тэр маш их зуд болоод л тэгээд л 93 оны зун цаг маш сайхан сайжраад л тэгэхэд л одоо ерөөсөө янз бүрийн бүр их настай хүн хүртэл миний мэдэхгүй ургамал ургасан байна л гэж л байсан. Тэгэхээр бол цаг сайжраад л байх юм бол би энэ ургамлын үндэс гэдэг чинь бол алга болчихдог эд биш юм байна гэж ойлгоод байгаа, цаг сайжраад байвал дороо ургаад л гараад л ирдэг, цаг муудаад байвал тэгээд л муу л байгаад л байдаг. Тэгээд цаг их учиргүй их муудлаа гээд тэр үндэс мүндэс огт алга болчихдог гайгүй юм болов уу . Зүгээр яахав эрдэмтдийн ярьж байгаагаар их л цөлжиж байна л гээд л байх юм. Тэгээд одоо сумын төв дээр ч гэсэн дээ одоо яг бид нарын бага байх үед энд огт элс байдаггүй байсан. Одоо л ер нь учиргүй элс нүүгээд байна гэж байгаа юм бага л харагдаж байгаа, зүгээр яахав хашааны ар мараар бол элс овоорох нь овоорч л байна. Тэгэхдээ нэг учир зүггүй нэг тийм онцгой цөлжөөд сүйд болоод байгаа юм ч юу л бол доо тэгээд нэг хэсэг нь бас гадаад дотоодоос төсөл мөсөл янз бүрийн юм авах гэж бас жаахан даваад бол ярихгүй бол болдоггүй ч юм бас байдаг биз дээ. Урьд бол мод чулуу гээд тариад байсан ч юм алга, урьд байсан мод, бут, хайлаас одоо унаад огт алга байхгүй болж ч байгаа юм алга, зүгээр би бол яахав зүгээр Манлай сумын хувьд бол учир зүггүй цөлжилт үүсээд хэцүүдсэн юм гэж бодохгүй байгаа.

Оюунтунгалаг -
Газар усны нэрүүд бол ер нь өөрчлөгдөв үү?

Сугир -

За яахав одоо энэ геологиуд чинь өөрсдийнхөө дураар л нэр өгөх юм байна шүү дээ, одоо ингээд тэгээд хайгуулын лицензтэй компаниудын одоо яг Манлай сумын нутагт одоо нэг 5 лицензтэй компани байлаа гэхэд нөгөө 5 нэрэнд яг Манлай сумын ард түмний нэрлэж байсан уул овоо нэр огт л байхгүй, дандаа л шинэ юм өгсөн л байх юм. Зүгээр яг орон нутагт байнга ажиллаж, амьдарч байгаа малчдын хувьд бол тэр газар усныхаа нэрийг учиргүй өөрчлөөд байгаа юм байхгүй байх аа. Урьд одоо бид нарын л нэрлэдэг байсан одоо тэр л Өлзийт уул муул ингээд л бүх юм одоогийнхоороо л байна, урдныхаараа л байна. Нэрэнд өөрчлөлт ороод байгаа юм гайгүй байх.

Оюунтунгалаг -

Тэгэхээр зэрэг геологийн ангиуд бас янз бүрийн нэр өгч бас газар усны нэр өөрчлөх хандлага байна тийм ээ?

Сугир -

Тийм, яг өөрсдийнхөө дураар нэр өгөх юм даа. Одоо ингээд манай сумын зүүн талд хүрэн үнэгт гээд нэг лицензтэй талбай байгаа юм л даа.

Оюунтунгалаг -

Хүрэн?

Сугир -

Үнэгт, үнэгт гээд. Үгүй ээ манай энд ерөөсөө ийм нэртэй газар байхгүй, яахаараа ийм нэртэй болчихов гэхээр зэрэг өө бид нарыг энэ талбай дээр ирэхэд нэг ийм сайхан улаан хүрэн үнэг бид нарыг зөв гарсан юм. Тэгээд бид нар хүрэн үнэгт гээд нэр өгсөн юм гэх жишээтэй.

Оюунтунгалаг -

Тэгж л өөрчлөгддөг?

Сугир -

Тийм, тэгж л өөрчлөгдөж байгаа юм биз тэгээд яахав дээ.

Оюунтунгалаг -

Танай энд чинь ер нь газрын гарц болоод тэр геологийн юу гэсэнээс өөрсдийнхөө нутгийн янз бүрийн нутгийн ард иргэд өөрсдөө газар усаа газар уснаасаа алт олборлож байгаа ч юм уу тэр ер нь газрын баялгийг ашиглаж байгаа юм байна уу?

Сугир -

За манай сумын нутагт бол ер нь шороон орд гэдэг юм нь байхгүй байна. Одоогоор илэрсэн юм байхгүй учраас тэрийг нэг ашиглаж байгаа юм алга. Аа зүгээр чулуун орд гээд үндсэн орд бол ганц нэг газар гарц багатайхан нэг жаал жаалхан юм гарсныг хүмүүс жаал жаалхан ухсан, тэгэхдээ тэр нь байгальд хор нөлөө үзүүлээд сүйд болсон юм нэг их байхгүй.

Оюунтунгалаг -

Тэр нэг ирак толгой гэл үү?

Сугир -

Тийм.

Оюунтунгалаг -

Танай нутгийн, нутагт байгаа газар уу?

Сугир -

Тэр Дорноговийн Хатан сумын нутагт байгаа. Тэгээд яахав Манлай тэгээд Ханбогд, Хатан сумын хилийн зааг руу л байгаа юм л даа. Гэхдээ манай сумаас бол хамаагүй ээ цаашаагаа тэр Хатан, Ханбогдын хилийн зааг дээр байгаа.

Оюунтунгалаг -

Тэр яагаад одоо тийм нэр авсан бэ?

Сугир -

Тэр одоо нөгөө 1 тонн чулуунаас гарах алтны хэмжээ их багаар нь одоо тэгээд хүмүүс тэгээд нэр өгсөн байгаа, тэгээд яахав Ирак толгой гээд тэр чинь уг нь Сүүж уул нэртэй газар юм байна л ээ. Тэрүүхэн тэндээ нөгөө алт олборлогч нар нь 3 газраас алт ухсан юм. Тэгээд хамгийн их одоо тонн чулуунаас хамгийн их гарцтай алт их гардагийг нь Ирак гээд нэр өгсөн, арай нэг бага гардагийг нь Богдад гээд нэр өгчихсөн, бас нэг арай нэг Иракаасаа хамгийн их гардагийг нь Кувейт гээд нэр өгсөн байсан байх, тэгээд дараагийнх нь Ирак дараагийнх нь Богдад гээд нэр өгсөн, тийм л юм байна л ээ. Тэгээд тэр алтных нь их багаас л тийм нэр өгсөн юм билээ. Тэгээд яахав Ирак, Кувейт энэ тэрийг их баян улс гэдэг утгаар нь тэгээд тэр газруудыг баян гэж үзсэн учраас л хүмүүс тэгээд нэр өгчихсөн, тэгээд тэр Сүүж уул гэдэг нэр үндсэндээ байхгүй болоод хүмүүсийн бол Ирак, Кувейт гэдгээр нь хүмүүс мэддэг болчихлоо л доо, за газрын өгөөжөөр л.

Оюунтунгалаг -

За баярлалаа

Back to top

Interviews, transcriptions and translations provided by *The Oral History of Twentieth Century Mongolia*, University of Cambridge. Please acknowledge the source of materials in any publications or presentations that use them.



 UNIVERSITY OF
CAMBRIDGE

MONGOLIA AND INNER ASIA STUDIES UNIT

DIVISION OF SOCIAL ANTHROPOLOGY

THE MOND BUILDING, FREE SCHOOL LANE

CAMBRIDGE CB2 3RF